ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/118/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/228
танай ____________-ны № ____________-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЯНЖМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 39,588.9 мянган төгрөгийн, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.Тухайлбал:

1. Бараа материалын нийт 37,259.0 мянган төгрөгийн орлого, зарлагыг цаг тухайд нь бүртгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, баталгаажуулалтгүй, жилийн эцсийн тооллогын баримтын бүрдэл хангалтгүй;
2. Нягтлан бодогч нь 2 байгууллагад зэрэгцсэн гэрээ байгуулан ажиллахдаа ижил ачаалалтай бусад нягтлан бодогчдоос 2,329.9 мянган төгрөгийн цалин илүү тооцон, шимтгэлийн зардал гаргасан.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.3.4, 6.4.1, 6.4.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.4, 20.2.5, 20.2.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "Үнэн ба зөв байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын шийдвэрээр сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 14,386.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Тус цэцэрлэг нь аймгийн Засаг даргын тамгын газраас 13,784.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус цэцэрлэг нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 89.4 хувтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **144,659,565.50** | **103,731,529.62** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | | **99,630,459.10** | **55,195,924.22** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | | **99,630,459.10** | **55,195,924.22** |
| **3121** | **Төгрөг** | | **99,630,459.10** | **55,195,924.22** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 99,630,459.10 | 55,195,924.22 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **45,029,106.40** | **48,535,605.40** |
| **354** | **Хангамжийн материал** | | **45,029,106.40** | **48,535,605.40** |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 2,528,830.00 | 1,540,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 36,746,876.40 | 42,617,076.40 |
| 35460 | Хүнсний материал | | 2,425,100.00 | 1,049,779.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 3,328,300.00 | 3,328,300.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **753,621,368.03** | **747,049,479.13** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **753,621,368.03** | **747,049,479.13** |
| **392** | **Биет хөрөнгө** | | **745,227,368.03** | **738,655,479.13** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 835,357,943.00 | 835,357,943.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (125,297,726.16) | (139,220,358.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 41,250,507.00 | 50,480,307.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (23,096,378.73) | (28,747,406.99) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 21,342,060.00 | 27,797,060.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (11,654,540.08) | (14,157,901.52) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 14,426,930.00 | 14,426,930.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (8,213,430.00) | (8,393,096.76) |
| 39217 | Ном | | 1,112,003.00 | 1,112,003.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | **8,394,000.00** | **8,394,000.00** |
| 39301 | Программ хангамж | | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (450,000.00) | (450,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 8,394,000.00 | 8,394,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **898,280,933.53** | **850,781,008.75** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | | **898,280,933.53** | **850,781,008.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **898,280,933.53** | **850,781,008.75** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | | 141,182,288.00 | 141,182,288.00 |
| 51102 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | 141,182,288.00 | 141,182,288.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | **757,098,645.53** | **709,598,720.75** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 707,688,217.09 | 757,098,645.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 49,410,428.44 | (47,499,924.78) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН** | | **898,280,933.53** | **850,781,008.75** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **2** | **410,360,450.00** | **385,359,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **34,049,950.00** | **385,359,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | **34,049,950.00** | **15,459,000.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – үндсэн хөрөнгө | | 26,682,500.00 | 13,784,800.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – бараа материал | | 7,367,450.00 | 1,674,200.00 |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | | **-** | **369,900,500.00** |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | | - | 369,900,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **376,310,500.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | **345,115,500.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 345,115,500.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | **31,195,000.00** | **-** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 31,195,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **358,950,021.56** | **432,859,424.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **358,950,021.56** | **432,859,424.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **357,926,066.01** | **430,786,221.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **246,911,050.94** | **289,045,255.71** |
| 210101 | Үндсэн цалин | | 184,341,169.05 | 187,965,377.31 |
| 210102 | Нэмэгдэл | | 52,674,371.89 | 83,343,683.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | - | 3,350,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 9,895,510.00 | 14,386,194.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **27,921,561.86** | **33,887,349.17** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 19,879,530.52 | 23,096,405.23 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 2,097,163.11 | 2,770,425.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 1,049,764.98 | 1,385,213.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 912,937.52 | 1,258,264.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 3,982,165.73 | 5,377,040.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **28,671,744.45** | **37,980,656.23** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 3,023,043.45 | 7,549,041.40 |
| 210302 | Түлш, халаалт | | 24,868,701.00 | 30,431,614.83 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 780,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **5,478,282.00** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,066,050.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 2,351,520.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 2,060,712.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | | **24,482,630.00** | **34,303,451.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 174,000.00 | 256,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 24,308,630.00 | 34,047,151.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **1,499,300.00** | **2,995,940.00** |
| 210604 | Урсгал засвар | | 1,499,300.00 | 2,995,940.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **2,263,000.00** | **1,870,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 2,263,000.00 | 1,870,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **20,698,496.76** | **30,703,568.90** |
| 210901 | Бараа ажил үйлчилгээний бусад зардал | | 2,096,700.00 | 7,118,880.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 260,000.00 | 1,328,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 18,341,796.76 | 22,256,688.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1,023,955.55** | **2,073,203.77** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | | - | 2,073,203.77 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | - | 2,073,203.77 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 2,073,203.77 |
| 2131124 | Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | - | 2,073,203.77 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | **1,023,955.55** | **-** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,023,955.55 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **4** | **51,410,428.44** | **(47,499,924.78)** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | **2,000,000.00** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | | 2,000,000.00 | - |
| **7** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (7)=(4)-(5)** | | **(2,000,000.00)** | **-** |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(4)+(5)** | **6** | **49,410,428.44** | **(47,499,924.78)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **376,310,500.00** | **369,900,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **369,900,500.00** |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **-** | **369,900,500.00** |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 369,900,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **376,310,500.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **376,310,500.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 376,310,500.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **347,479,247.80** | **414,335,034.88** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **347,479,247.80** | **414,335,034.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **346,455,292.25** | **412,261,831.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **246,911,050.94** | **289,045,255.71** |
| 210101 | Үндсэн цалин | 176,556,594.67 | 187,965,377.31 |
| 210102 | Нэмэгдэл | 60,458,946.27 | 83,343,683.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 3,350,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,895,510.00 | 14,386,194.99 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,921,561.86** | **33,887,349.17** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,879,530.52 | 23,096,405.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,097,163.11 | 2,770,425.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,049,764.98 | 1,385,213.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 912,937.52 | 1,258,264.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,982,165.73 | 5,377,040.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,671,744.45** | **37,980,656.23** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,023,043.45 | 7,549,041.40 |
| 210302 | Түлш, халаалт | 24,868,701.00 | 30,431,614.83 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 780,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **25,258,760.00** | **32,671,830.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 25,258,760.00 | 32,671,830.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,499,300.00** | **2,995,940.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,499,300.00 | 2,995,940.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,158,000.00** | **1,870,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,158,000.00 | 1,870,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **15,034,875.00** | **13,810,800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,706,575.00 | 10,608,550.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,328,300.00 | 3,202,250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,023,955.55** | **2,073,203.77** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 2,073,203.77 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 2,073,203.77 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 2,073,203.77 |
| 2131125 | Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 2,073,203.77 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,023,955.55** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,023,955.55 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **28,831,252.20** | **(44,434,534.88)** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)** | **511,500.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **511,500.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **511,500.00** | **-** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 511,500.00 | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(511,500.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **28,319,752.20** | **(44,434,534.88)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **71,310,706.90** | **99,630,459.10** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **99,630,459.10** | **55,195,924.22** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **141,182,288.00** | **707,688,217.09** | **848,870,505.09** |
| Тайлант үеийн үр дүн | - | 49,410,428.44 | 49,410,428.44 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **141,182,288.00** | **757,098,645.53** | **898,280,933.53** |
| Тайлант үеийн үр дүн | - | (47,499,924.78) | (47,499,924.78) |

| | | | |
|---|---|---|---|
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **141,182,288.00** | **709,598,720.75** | **850,781,008.75** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **327,123,300.00** | **326,850,700.00** | **(272,600.00)** | **99.9** |
| **12** | **Татварын бус орлого** | **327,123,300.00** | **326,850,700.00** | **(272,600.00)** | **99.9** |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **327,123,300.00** | **326,850,700.00** | **(272,600.00)** | **99.9** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 327,123,300.00 | 326,850,700.00 | (272,600.00) | 99.9 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **412,757,300.00** | **371,285,234.88** | **(41,472,065.12)** | **90.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **412,757,300.00** | **371,285,234.88** | **(41,472,065.12)** | **90.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **412,757,300.00** | **371,285,234.88** | **(41,472,065.12)** | **90.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **322,615,300.00** | **289,045,255.71** | **(33,570,044.29)** | **89.6** |
| 210101 | Үндсэн цалин | 202,730,300.00 | 187,965,377.31 | (14,764,922.69) | 92.7 |
| 210102 | Нэмэгдэл | 114,810,500.00 | 83,343,683.41 | (31,466,816.59) | 72.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 3,350,000.00 | 3,350,000.00 | - |
| 210104 | Урамшуулал | 5,074,500.00 | 14,386,194.99 | 9,311,694.99 | 283.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **40,124,800.00** | **33,887,349.17** | **(6,237,450.83)** | **84.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,220,200.00 | 23,096,405.23 | (4,123,794.77) | 84.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,226,100.00 | 2,770,425.56 | (455,674.44) | 85.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,613,100.00 | 1,385,213.78 | (227,886.22) | 85.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,613,100.00 | 1,258,264.44 | (354,835.56) | 78.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,452,300.00 | 5,377,040.16 | (1,075,259.84) | 83.3 |
| **2105** | **Нормативт зардал** | **34,103,900.00** | **32,671,830.00** | **(1,432,070.00)** | **95.8** |
| 210502 | Хоол, хүнс | 34,103,900.00 | 32,671,830.00 | (1,432,070.00) | 95.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,874,600.00** | **1,870,000.00** | **(4,600.00)** | **99.8** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 1,874,600.00 | 1,870,000.00 | (4,600.00) | 99.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,038,700.00** | **13,810,800.00** | **(227,900.00)** | **98.4** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,831,500.00 | 10,608,550.00 | (222,950.00) | 97.9 |
| 210902 | Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал | 3,207,200.00 | 3,202,250.00 | (4,950.00) | 99.8 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **(85,634,000.00)** | **(44,434,534.88)** | **-** | **-** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **85,634,000.00** | **44,434,534.88** | **-** | **-** |

### 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **43,049,800.00** | **43,049,800.00** | **-** | **100.0** |
| **12** | **Татварын бус орлого** | **43,049,800.00** | **43,049,800.00** | **-** | **100.0** |
| **122** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **43,049,800.00** | **43,049,800.00** | **-** | **100.0** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 43,049,800.00 | 43,049,800.00 | - | 100.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **43,049,800.00** | **40,976,596.23** | **(2,073,203.77)** | **95.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **43,049,800.00** | **40,976,596.23** | **(2,073,203.77)** | **95.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **43,049,800.00** | **40,976,596.23** | **(2,073,203.77)** | **95.2** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **40,049,800.00** | **37,980,656.23** | **(2,069,143.77)** | **94.8** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,549,100.00 | 7,549,041.40 | (58.60) | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 32,500,700.00 | 30,431,614.83 | (2,069,085.17) | 93.6 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **3,000,000.00** | **2,995,940.00** | **(4,060.00)** | **99.9** |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,995,940.00 | (4,060.00) | 99.9 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **2,073,203.77** | **-** | **-** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **(2,073,203.77)** | **-** | **-** |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 275,518.4 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн Улсын төсвөөс санхүүжих төлөвлөгөөг 264,441.9 мянган төгрөгөөр бууруулсан, орон нутгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 2,073.2 мянган төгрөг, нийт 266,515.1 мянган төгрөгийн тохируулга хийгээгүй байна. | 1 | 266,515.1 | 1 | 266,515.1 | | | 1 | 266,515.1 | | | | |
| Шатахуун, бичиг хэргийн материал, аж ахуйн материалын зарлагыг Бараа материал худалдсаны зардал дансанд буруу бичилт хийж, зардлууд нэр төрлөөр тайлагнагдаагүй байна. | 1 | 7,103.3 | | | 1 | 7,103.3 | 1 | 7,103.3 | | | | |
| Эрхлэгчийн 2025 оны А/14 тушаалаар Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хивсийг хөрөнгийн зардлаар хүлээн | 1 | 1,900.0 | | | 1 | 1,900.0 | 1 | 1,900.0 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| зөвшөөрч тайлагнаагүй аж ахуйн материалд орлого авсан алдаа байна. | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **275,518.4** | **1** | **266,515.1** | **2** | **9,003.3** | **3** | **275,518.4** | | | | |

**3.2** Аудитаар нийт 39,588.9 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс 2,329.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 1 төлбөрийн акт, 37,259.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| **Зөрчлийн товч утга** | **Нийт зөрчил** | | **Үүнээс** | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцуулах албан шаардлага** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Албан тушаалтны тоо** | **Тоо** | **Дүн** |
| Нягтлан бодогч нь 2 байгууллагад зэрэгцсэн гэрээгээр ажиллахдаа цэцэрлэгээс 2,329.9 мянган төгрөгийн цалин илүү тооцсон байна. | 1 | 2,329.9 | 1 | 2,329.9 | | | | | | | | |
| Бараа материалын зарлагыг цаг тухайд нь бүртгэдэггүй, анхан шатны баримтыг бүрдэл баталгаажуулалтгүй, жилийн эцсийн тооллогын | 1 | 37,259.0 | | | | | 1 | 37,259.0 | | | | |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| баримтын бүрдэл хангалтгүй байна. | | | | | | | | | | | | |
| Эцэг эх, асран хамгаалагчдын хандиваар бэлтгэсэн бараа материалын тооцоог хийж, данс бүртгэлд тусгахгүй, багш нарын гар бүртгэлээр хяналт тавьдаг байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **3** | **39,588.9** | **1** | **2,329.9** | | | **2** | **37,259.0** | | | | |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 1 зөрчил илэрч, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд ил тод 118 мэдээлэл байршуулахаас төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар зэрэг нийт 6 мэдээлэл хугацаа | 1 | - | | | | | 1 | - | | |

ТӨА-2026/118/НА-СТА-ТШЗ

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хоцроож, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, нийт 36 мэдээллийг огт байршуулаагүй, журмын хавсралт, маягтын дагуу мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв оруулаагүй байна | | | | | | | | | |
| | **Дүн** | **1** | **-** | | | | **1** | **-** | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn